

**СОЦИАЛИЗМЫН ҮЕИЙН МОНГОЛЫН СОЁЛЫН ӨӨРЧЛӨЛТ:
ЦАГААН САРЫН БЭЛЭГ СОЛИЛЦОХ ЁС**

Г. Нандинбилиг *

Түлхүүр үг: Монгол, бэлэг, цагаан сар, бэлгэдэл, соёлын өөрчлөлт

Бид өмнөх судалгаандаа МНТ-нд уламжилж ирсэн “хувь өгөх” харилцааны соёлыг В.Инжаннашийн “Хөх судар” ба Саган Сэцэний “Эрдэнийн товч”-д гарч байгаа бэлгийн дүр, харилцааны соёлтой харьцуулж үзээд, эцэг эхээс хөвүүд дүү нартаа өвлүүлэн өгсөн өөрийн язгуур соёлын ололт болох мал идээ, балгад иргэнийг “хувь” гэж, харин ураг хурим, шашин төрийн харилцаагаа батлах зорилгоор өгч авсан морь мал, эрдэнэс, эд агуурс зэрэг гол төлөв бусдын соёлын ололтыг “бэлэг” гэж ялган нэрлэдэг ялгаатай уламжлал байгаа талаар судлан тогтоосон билээ.

Харин энэ удаа монголчуудын бэлэгний соёл сэтгэлгээ, тэр дундаа цагаан сарын бэлэгний соёлд гарсан өөрчлөлтийг тодруулах зорилго тавьсан болно.

Монгол угсаатны эрхэм хүндтэй хүндээ өргөдөг бэлгэдлийн гүн утга шингэсэн бэлэг болох есөн цагааны бэлгийн талаар энд үл өгүүлэн өгүүлэхэд монголчуудын мал ахуйн соёл сэтгэлгээний хүрээнд хүргэн болон ач зээдээ хурдан удмын унага даагаар, бэр болон шинэ мэндэлсэн ач зээдээ сүүтэй үнээ болох охин тугал бяруугаар, худ худгуй нар болон хамаатан садандаа халзан цагаан хониороо бэлэг барих ёс түгээмэл дэлгэрч, хонь бол ерөөс нэг сайн бэлэг дурсгалын утгатай болсон байдаг.

Мал адуусыг бэлгэнд сонгох бэлгэдлийн ангиллын анхдагч шалгуур нь **“өсч үржих тооны”**- **“цагаан цайвар өнгө зүстэй”** гэсэн шинжээр тодорхойлогдож, харин ганц юм уу бараан эд зүйлс нь ганцдах хомстох муу ёртой тул бэлгэнд өгч болохгүй гэсэн бэлэгний бэлгэдлийн ангиллыг бүтээжээ.

Бэлэгний соёл бол монголчуудын хувьд дан ганц эрхлэх аж ахуй, соёлынхоо ололт дэвшлийг хуваалцах хэрэглээний ойлголт төдий биш бөгөөд ураг хуримын харилцаа, хэлхээ холбоогоо батлах соёлын давхар утга үүрэгтэй ажээ. Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд бэлэг өгөх ёс нь ураг хуримын ёслолын салшгүй хэсэг болох нь батлагдах төдийгүй өөрийн хүү, хүүхэнд өгч буй мал идээг “хувь” гэж нэрлэж байгаа, айлын бэр болсон хүүхэн ба хүргэндээ, худ худгуйнханд барьж буй бол “бэлэг” гэж нэрлэж байгаа нь ялгаран харагдана. Социализмын жилүүдэд орон нутагт хийсэн монголын угсаатны зүйн хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнээс хуримын сүй бэлэгтэй холбогдолтой баримтууд нэн элбэг бөгөөд цөөхнийг дурдвал:

* Монгол Улсын Их Сургууль, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

Хүснэгт 1

Цаг, орон	Хуримын сүй бэлгийн ёс
1964 онд Архангай аймгийн Чулуут Тариат сум	“...хүүгийн тал хүүхэн гуйхад 5,7,9-ийн сүй бэлэг хэрэгтэй гэх авч энэ нь өгсөн сүйг бэлтгэж чадахаа батална.. хургэндээ морь заавал <u>бэлэглэнэ</u> ...хүүгийн тал хүүхний талаас ирсэн улсад <u>бэлэг</u> тараана...3-7 хоногийн дараагаар эргэлтэнд аав хонины махтай, өөр бусад <u>бэлэгтэй</u> ирж барина. Хүүхэндээ дээлийн өнгөтэй ирнэ...” (Лхамхүү 70 настай, Сүрэнжав 66 настай МУЗХСЭХ., 2011, 1, 135-136.)
1966 он. Ховд аймгийн Манхан сум	“...мөргүүлсэн хадмууд бэрдээ мал амлах буюу бэлэг өгнө. Ил гарсан бэр өвчүү тавиулж найрлана...” (захчин хошуу, Түгжээ 49 настай МУХСЭХ., 2011, 1, 195),
1978 он. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум	“ах дүүсээр айлчлахад охин бэлэг өгдөггүй...хүүгийн тал бэлэг өгнө. Бэлгийг аав ээж, ах дүү нарт тохируулж өгнө. Үүнд эцэгт хадаг, дээлийн өнгө, эхэд дээлийн гадар, төрөл садан эрэгтэйд цай, эмэгтэйд хар улаанаас бусад өнгөтэй бөс өгнө” (С. Батхуяг, нас 23, эр, өөлд, Ц.Гүнчин-Иш, нас 61, эр, өөлд, МУХСЭХ., 2011, 4, 33),
1988 он. Ховд аймгийн дуут сум.	Зочид шинэ гэр бологсдод бэлэг өгдөг. Бэлэгт дээлийн торго, сав суулга, аяга зэрэг орно. (МУЗХСЭХ., 2011, 10, 74) Айлын бэр болсон хүн ах дүү нарынхаа урилгаар айлчлал хийнэ. Урьсан ах дүү нар заавал бэлэг сэлт өгч, мал зүслэн зааж өгдөг. хүүгийн талын ах дүү нар бэрд заавал өвчүү чанаж өгдөг. (Д.Самдан. 64 настай, эр, мянгад МУЗХСЭХ., 2011, 10, 75)
1988 он Ховд аймаг	Гэрийн бүрлэг сайхан болж байна гээд ерөөлийн үг хэлж бэлэг сэлтээ өгнө. ...найр дуусах үед тэр айл ирсэн зочдод бүгд нь гар цайлгана гэж хэлээд өгсөн юмыг нь дүйлгэн хариу бэлэг өгдөг. Дээд тал нь дээлийн өнгө, цагаан даавуу даалимба зэрэг болно. (МУЗХСЭХ., 2011, 10, 260)
1989 он Баян-өлгий аймгийн Булган, Сагсай сумд	Өөр хошууны ноёны охинтой суухад есөн цагааны бэлэг өгдөг байжээ.Үүнд, цагаан морь, алтаар мушгисан бурантагтай мөнгөн товхтой тэмээ, цагаан үнэгний арьс, ембүү, цагаан ам чичүү, жан хадаг, вам хадаг, цагаан булганы арьсыг өгдөг байжээ. Ембүү нь тавин лангийн ембүү байдаг”(Оорцог сум. Ноостын Увш. 63 настай, МУЗХСЭХ., 2011, 10, 198)

Чухам хэнд юугаар бэлэг өгдөг тухайд нарийвчлан шүүж үзвэл “...хүүгийн тал бэлэг өгнө. Бэлгийг аав ээж, ах дүү нарт тохируулж өгнө. Үүнд эцэгт хадаг, дээлийн өнгө, эхэд дээлийн гадар, төрөл садан эрэгтэйд цай, эмэгтэйд хар улаанаас бусад өнгөтэй бөс өгнө” (МУХСЭХ., 2011, 4, 33), “...хүүгийн даахинд...хүүхдэд аяга, хувцас өгсөн ирсэн хүмүүст даалимба, торго зэргийг 1м цагаан даавуутай өгсөн. Бараан өнгө муу, цагаан өнгийг бэлэгтэй гэж өгдөг.” (МУХСЭХ., 2011, 4, 39. “...Хүүхнээ хүнд өгөхдөө наанадаж таван зах дээлтэй явуулна. Хурган дээлгүй явуулсан бол төрхөмчилж ирэхэд хурган дотор бэлэглэнэ. Хуучин цагт элдсэн хурганы арьс барьж золгож байсан гэдэг. ” “Эхнэр төрхөмдөө дараа жилийн эхинд Цагаан сараар очсон. Ээждээ цай чихэр, аавдаа чихэр өгсөн. Эх эцэг охиндоо дээлийн гадар тус бүр нэгийг өгсөн...ах дүү нараар айлчилсан. Гар цайлгаж, чихэр, бас даавуу, мөнгө зэргийг өгнө. (МУХСЭХ., 2011, 4, 45)

Монголчууд ураг төрлийн харилцааг ийнхүү ил тодорхой бүтээж, хэнд ямар бэлэг өгөх талаар нарийн ангилал бүтээсэн байжээ.

Хүснэгт 2

Хэнд ?	Хувь	Бэлэг
Аав ээж, авга, нагац нарт	Ууц, бүхэл шүүс, тос өрөм, шимийн охь, хадаг, мөнгө	
Хөвүүд ба гал зээд	Гэр, мал	
Ач, гуч нарт	унага даага, охин тугал бяруу, охин хурга, хувь идээ	
Охидод	тугалтай үнээ, охин бяруу тугал, хувь идээ, ор дэр, дээл хувцас, сав суулга гэх мэт	Айлын бэр болсон хойно дээлийн торго сэлт
Бэргэд, бэрүүдэд	Тугалтай үнээ, дээлийн торго, сав суулга	
Зээ нарт		охин хурга, аяга, чихэр
Хүргэдэд		бүс, дурдам
Худ, худгуй нарт		Хадаг, цай, дээлийн торго
Хүргэний ах дүүс, бусад зочдод		Эмжээр хоргой, тамхи, чихэр зэргээр гар цайлгах

Дээрх хууч ярианаас анхаарал татаж буй нэг зүйл болангийн арьс үсээ өргөн барих эртний монголчуудын соёл нь элдсэн хонь хурганы арьсаар бэлэг барих болж байгаад, даруй дээлийн өнгө торго зэргийг бэлэглэх болсон жишээнд соёлын өөрчлөлт харагдахын хамтаар өнгө, дүрс, тооны бэлгэдлээ ч уламжилсан нь ажиглагдана. Хүнд барих бэлэгний өнгө, тоо, хэлбэр дүрс тэргүүтнийг эрхэмлэх энэ ёс нь монголчууд бэлгэнд хэрэгцээний утгаас илүү бэлгэдлийн харилцааг чухалчилж ирснийг гэрчилж байна.

Уламжлалт соёлын бэлгийн дүрүүдээс гадна бусдын соёлоос таашаан авч, өөрсдийн бэлгэдэл утгыг нэмэн баяжуулж хөгжүүлсэн бэлгийн зүйл арвин байна. Цагийн хүрдийг жаахан хойшлуулбал жинчдээр дамжин орж ирдэг торго дурдан, еэвэн, багачуудын мөрөөдөл болсон мөсөн чихэр зэргийг цагаан сарынхаа зочдод бэлэглэдэг байсан тухай хууч яриа элбэг бий. Манжийн ноёрхлын үед зэргэлдээх улс үндэстний соёлын ололтоос, тэр дундаа хятдын соёлоос хоргой, торго зэрэг энтэй артай бөс эдлэлийн зүйлийг таашаан хүлээж авч, монгол бэлгийн соёлд торгон дээлийн өнгө, дурдам бүс, эмжээрийн хоргой, шаазан аяга, шахмал цай, тамхи, еэвэн зэргээр баяжсан ажээ. Монгол ёс заншлын дунд тайлбар тольд тэмдэглэсэнчлэн “.. бод бог мал, торго дурдан, хувцас хунар, алт мөнгө хийгээд хавтага, эрих, хутга, аяга, алчуур, хадаг, цай болон цагаан идээ, чихэр боов, мөнгө төгрөг бэлэглэдэг болсон заншилтай. Мөн хонилж, архилж ирэхийг их бэлэгт үздэг... Гэхдээ бэлгийн зүйл нь цаг цагаар өөрчлөгдөн, үе үеийн бэлгийн үнэлэлт өөр болдог. Хэдий тийм боловч монголчуудын хувьд хадаг, аяга, цай зэрэг нь нэн хүндтэй бэлэгт ордог...” (Ч.Арьяасүрэн, Х.Нямбуу, 1991,52-54) ажээ.

Улмаар харь соёлын эд идээн бэлэглэх болсон энэ үеэс монголчуудын “үстэй хөрстэй арьсан эдлэл”-ийг үнэлэх үнэлэмж нь “энтэй артай бөс торго”-д шилжин хувирч, “эвлүүлж шахсан бяслаг, тос” идээний бэлгэдэл нь “шахмал цай, еэвэн”-д хэрхэн шилжин хувирсныг ойлгож болно. Харилцаа холбоо хөгжиж, харийн соёлын ололтоос хуваалцаж, содон сонин эд идээний зүйлийг бие биедээ бэлэглэх болсоноор монголчуудын бэлэгний соёл дахь “өсч үржих тоо”- “цагаан цайвар өнгө зүс” гэсэн

бэлгэдлийн ангиллын анхдагч шалгуур дээр **тэгш дөрвөлжин хийгээд дугуй дүрсийг таашаах**, мэс зэв мэт хурц өнцөгтэй гурвалжин дүрстэй бол хүнд өгөхийг цээрлэх дүрсийн бэлгэдэл нэмэгдэж, ангиллын удаах шалгуур нь **“энтэй артай эд- эвлүүлж шахсан идээн”** гэсэн шинэ шалгуураар баяжсан байна.

“Бэлгийн морины шүдийг татдаггүй” цээрийн соёлтой энэ ард түмний бэлгийн үнэ ханшийг тооцон бодох аж хэрэглээний сонирхлоо халж чадсан соёлын нэгэн дэвшил бол хадаг гэж болно. Бурханы шашны нөлөөгөөр хадгийн соёл нэвтэрч, эгэл хүн хэрхэн Буддын шашинд орж, ном сонсон сайжирч, гэгээрэхийн бэлгэдэл болохөлзийт найман тахил ба төрийн долоон эрдэнэ зэрэг олон зүйл бэлгэдэл утгаар баяжиж, настанд хадаг барин золговоос нас уртасч, буян дэлгэрнэ гэсэн итгэл бишрэлээр гэгээн өнгөт хадгийг ураг хуримын болоод цагаан сарын соёлдоо нэвтрүүлсэн байна. Хадагны соёлын хувьд “хадаг барин золгох”, хадаг ховор цагт “хадагтай гараар золгох” буюу гарын ядам хурууг хадгаар ороож золгох ёс бий болсон зэрэг нь монголын цагаан сарын соёлд шинэ бэлгэдэлт санаа оруулсан томоохон өөрчлөлтийн нэг болно. Ийнхүү монголчуудын бие биедээ барих бэлэг нь дорно дахины улс үндэстний соёлын ололтоос өөртөө оруулж, дүрийн хувьд баяжсан ч бэлгэдэл, цээрийн уламжлалт соёлоо хадгалан үлдсэн байна. Эдгээр нь монголчууд энэтхэг, төвд, манж, хятад зэрэг бусад дорно дахины ард түмний соёлтой түүхийн урт хугацаанд харилцаж ирсэн нь монголчуудын бэлгийн соёлд нөлөөлсөн бөгөөд монголчууд харь соёлын зүйлсийг оруулахдаа өөрсдийн язгуурын “өнгө, тоо, дүрсийн бэлгэдэл”-ийн шалгуураар шүүх замаар зарим тэмдэг бэлгэдлээ өөрчлөн баяжуулж байсан өвөрмөц онцлогийг илтгэнэ.

Бидний бодлоор соёлын тогтвортой байдлыг хадгалдаг гол элемент нь бэлгэдэл болно. Соёлын хамгийн чухал элемент болох бэлгэдэл бол Түрнэрийн хэлсэн шиг тогтворгүй хувиран өөрчлөгдөж байдаг нөхцөлт чанартай биш болох нь монголчуудын бэлгийн жишээн дээр авч үзэхэд батлагдаж байна. Цаг үе өөрчлөгдөхөд бэлгийн дүр л өөрчлөгдөж байгаагаас түүний бэлгэдэлт утга төдий л өөрчлөгдөөгүй байна.

Тэгвэл социализмын жилүүдэд бэлэгний соёлд ямар өөрчлөлт орсон бэ гэдэг асуулт зүй ёсоор гарч ирнэ.

1952 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр битүүний өдөр Х.Чойбалсанг насбарсныг далимдуулж улс орон даяар гашуудал зарлан, баяр тэмдэглэхийг хориглосон байдаг. Өнөөгийн ахмад сэхээтнүүдийн хууч ярианд 1960-аад оноос цагаан сарыг зөвхөн малчдын баяр, нэгдэлчдийн баяр болгож, нийтээрээ тэмдэглэхийг болиулсан ба энэ жилүүдэд хэрхэн нууж золгодог байсан тухай өгүүлдэг. Ийнхүү улс төрийн зорилгоор нэгэн үе цагаан сарыг хориглож малчны баяр нэрээр даруухан тэмдэглэж, цагаан сарыг тэмдэглүүлэхгүй гэж ажлын байран дээр нь ирц бүртгэж, сүлд модны наадмыг өргөн дэлгэр тэмдэглэх болсноор монголчууд бэлгийн талаарх ойлголт “өвлийн өвгөний бэлэг” гэсэн ойлголтоос суралцаж, хот суурингийнхны хувьд цагаан сараар бэлэг бэлдэж, өгч авах соёлд нөлөөлсөн бололтой.

Малчид цагаан сараа хэрхэн тэмдэглэж байсан талаар мэдээлэл хайж, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс орон нутагт ажилласан хээрийн судалгааны тайлан хэрэглэгдэхүүнийг шүүж үзэхэд 1960-1971 онд Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Ховд, Дорноговь, Дундговь, Хэнтий, Төв аймгуудад ажилласан тайланд цагаан сарын тухай мэдээлэл байхгүй байгаа бол 1971-1972 онд Увс аймагт хийсэн хээрийн судалгааны тайланд цагаан сараар ендэрт мөргөж, цацал цацах ёслолын тухай мэдээ баримт орж ирсэн ч бэлэгний талаар огт дурсахгүй байгаа нь сонирхолтой. Цагаан сарын бэлэгний талаар анх мэдээлсэн тухайд бол 1973 онд Дорнод аймгийн

Дашбалбар суманд хийсэн хээрийн шинжилгээний тайланд “...шинийн нэгний өглөө эрэгтэй эмэгтэй залуус мордож золгоно. Тэгэхдээ настай хүмүүсийн алган дээр хадаг тавина. Одоо бол бөс даавуу өгнө...бэр мөргөсөн хадмуудтайгаа бэлэг барьж золгохгүй... цагаан сараар хонь алж, ууц төөлэй тавина- хувь бэлтгэнэ” (МУЗХСЭХ., 2011, III, 292) хэмээн дурдсан байна. Дараа нь 1978 онд Ховд аймгийн Манхан суманд ажилласан хээрийн шинжилгээний хэрэглэгдэхүүн дотор халхын ул боов сумын төвд дэлгэрч байгаа талаар мэдээлээд, “хүүхдүүд үнсүүлж цагаална, аав ээж нь бэлгээ өгнө...настай хүнтэй цагаалахдаа хадаг барьж, цагаалгаар бэлэг өгнө”(МУЗХСЭХ., 2011, IV, 253), “... урьд хадаг эсвэл цагаан бөс эд гээд бэлэг сэлт томорч байна” (МУЗХСЭХ., 2011, IV, 262), “...одоо зарим нь төгрөг, алчуур өгч цагаалж байна. Мэнд мэдэж цагаалсны дараагаар хадаг, эсвэл алчуур, төгрөгөөр бэлэг өгнө” (МУЗХСЭХ., 2011, IV, 286) гэхчлэн цагаан сарын ёслолын талаар гурвантаа тэмдэглэл орж ирсний дотор бэлэгний талаар тодорхой дурдсан байна.

Социализмын жилүүдэд орон нутагт хийсэн монголын угсаатны зүйн хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнээс цагаан сарын бэлэгтэй холбогдолтой баримтуудыг бүртгэн авч үзвэл :

Хүснэгт 3

Цаг, орон	Цагаан сарын ёс
1972 он. Увс. Тэс.	Шинийн өглөө...ендэр дээр идээний дээжээс гадна уураг чанаж, эсвэл цагаан юм заавал аваачна. Сан тавьж, залаа залмаа хатгаад ендэрт мөргөнө. Чанаж очсон уургийг хамгийн отгонд бариулж, хамгийн ахмад нь цацал цацна. Тайж нартай зэрэгцэн цацал өргөнө. Ясан төрлөөр цацал нэг байна...” (1972 он. Увс. Тэс. Н.Бүрнээбаатар 62настайМУЗХСЭХ., 2011,VI,163)
1973он, Дорнод. Дашбалбар	“...Шинийн нэгний өглөө настай хүмүүсийн алган дээр хадаг тавина. Одоо бол бөс давуу өгнө... бэр мөргөсөн хадмуудтайгаа бэлэг барьж золгохгүй... цагаан сараар хонь алж, ууц төөлэй тавина- хувь бэлтгэнэ”(1973он, Дорнод. Дашбалбар. Намжил МУЗХСЭХ., 011,III,292)
1977 он. Увс. Наранбулаг сум	“...Цагаалганы өдөр ойр настай айлдаа ирж цагаална. Цагаалахдаа архитай, хадагтай очно. Сүүл үед хадаггүй болоод цагаан бөс, цай, цамц гэх мэт барьж золгох болоод байна. Залуучууд хоорондоо гар хоосон цагаална...”1977 он. Увс. Наранбулаг. Ө.Цэвээн, эр, нас 29,МУЗХСЭХ., 2011,III,129
1978 он. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум	Цагаан сараар 2-3 нял таваг идээ засдаг байв. Харин сүүлийн үед нэг том таваг, дагуулж жижиг таваг засах болоод байна.Махаар таваг засч байгаагүй. Цагаалгаар хүү нь эцэгтээ золгохдоо ууцтай ирдэг. Урд хадаг, эсвэл цагаан бөс гээд бэлэг сэлт томорч байна (1978 он. Ховд. Эрдэнэбүрэн, Ц.Гүнчин-Иш, нас 61, эр, өөлд, МУЗХСЭХ., 2011, IV,262)
1978 он. Ховд аймгийн Манхан сум	...сүүлийн үед айлууд дээж махан тавихаа болиод байна. Овоонд мөргөх ёс уурч байна...Настай хүнтэй цагаалахдаа хадаг барьж, цагаалгаар бэлэг өгнө. Бусад улс хоорондоо цагаалаад бэлэг өгнө... (1978 он. Ховд. Манхан, Д.Галхуу, нас 39, эр, захчин, МУЗХСЭХ., 2011, IV,253)

1978 он. Увс аймгийн Тариалан сум	“Эхнэр төрхөмдөө дараа жилийн эхинд Цагаан сараар очсон. Ээждээ цай чихэр, аавдаа чихэр өгсөн. Эх эцэг охиндоо дээлийн гадар тус бүр нэгийг өгсөн...ах дүү нараар айлчилсан. Гар цайлгаж, чихэр, бас даавуу, мөнгө зэргийг өгнө. (1978 он, Увс аймгийн Тариалан сум.Шуудгайн Санж, нас 35, хотон, МУЗХСЭХ., 2011, 4, 45) “... Одоо цагаан сараар төвөөс улс ирэх болж, ууц толгой тавих болоод байна...дээр цагаалахдаа хадаг, одоо төгрөг, алчуур өгч цагаалж байна...” (1978 он. Увс. Тариалан, Мягмар, нас 72, эр, захчин, МУЗХСЭХ., 2011, IV,284)
1980 он. Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум	Цагаан сараар...цагаан идээгээр зассан тавагтай идээгээр зочлоно. Бас хурууд, бор тос гарт нь авч өгдөг... (1980 он. Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум, Д.Дуламсүрэн, 78н, эм, урианхай, МУЗХСЭХ., 2011,V,220)
1982 он. Говь-Алтай аймгийн Тонхил сум	Шинийн нэгэнд ...хүүхдүүдээ хувь гэж бөөрөнхий тос нэг нэг боов өгдөг.. Дахилын цай 3 хоноод ууж, бүсгүйчүүд бие биедээ ороо даавуу өгч, хонинд явсан хүнд өгдөг бэлгээ өгнө...Хотондоо золгоод авга, нагац ахындаа очиж золгоно. Аав ээжийн бэлэг гээд нэг хадагтай, ууц, дал, шилт сээр чанаж очно...(1982 он. Говь-Алтай аймгийн Тонхил сум, Сүхноолтуур, нас 82, эр, халх, МУЗХСЭХ., 2011,VI,181)
1982 он. Говь-Алтай аймгийн Тонхил сум	Цагаан сараар өндөр настанд дал дөрвөн өндөр, ууц, эмэгтэй хүнд өвчүү чанаж өгдөг. Харьд гарсан охиндоо өвчүү чанаж өгнө... Цагаан сараар настанг зочлоод явахад хадаг, чихэртэй өгнө. Одоо бол тамхи, нүүр гарын алчуур, цамц, оймс, майк өгнө. Эмэгтэй хүнд жусаа утас, хошоо тууз өгдөг байсан... (1982 он. Говь-Алтай аймгийн Тонхил сум, С.Таглин, нас 74, эр, халх, МУЗХСЭХ., 2011,VI,163)
1982 он. Говь-Алтай аймгийн Тонхил сум	“Шинийн нэгэнд настан болон аавындаа хадагтай орж золгоно... Шинийн нэгэндээ цай л уучихна, бэлэг сэлтгүй.Гурав хоног дахилтны цай гэж бие биендээ цай ууцгаан, бэлэг сэлтээ барина. Тамхины уут, хөөрөгний ав мэтийг урьд эр хүнд өгдөг байсан. Одоо бол дээлийн торго, цамц, тамхи өгөх болжээ. Эм хүнд хошоо тууз, ороон торго барьдаг байсан. Одоо юм элбэгшээд дээлийн торго өгөх болжээ” (1982 он. Говь-Алтай. Тонхил, Ө.Түвдэн 77н, эр, халх, МУЗХСЭХ., 2011, VI,160) “Цагаан сараар өндөр настанд дал дөрвөн өндөр, ууц, эмэгтэй хүнд өвчүү чанаж өгдөг. Настанг зочлоод явахад хадаг чихэртэй өгдөг байсан. Одоо бол тамхи, нүүр гарын алчуур, цамц, оймс, майк өгнө. Эмгэн, залуу эмэгтэй хүнд жусаа утас, хошоо тууз өгдөг байсан” (1982 он. Говь-Алтай. Тонхил, С.Таглин 74н, эр, халх, МУЗХСЭХ., 2011, VI,163)
1987 он. Ховдын Эрдэнэбүрэн сум	Цагаан сараар ...настайчуулдаа очно. Дүү нар нь бол эгчдээ ахдаа, авга ахдаа, хадмындаа ууцтай, боовтой очно. Боов гэдэг нь дугуй боов.. Хадамд гарсан бэрчүүд эцэг эхдээ ууцтай очно. Ууц бол хөгишин хүний дээж...үнэндээ ууц өвчүүнүүд солигдож байдаг...(1987 он. Ховдын Эрдэнэбүрэний харьяат. Пэрлээ 74 нас, эр, өөлд, МУЗХСЭС, 2011,IX, 220)

Дээрхээс үзэхэд эрхлэх аж ахуй, амьдралын хэвшил өөрчлөгдсөн сүүлийн зуун жилд ураг хуримын эргэлт болоод айлчлалын ёслол хураагдаж, цагаан сартай нэгтгэн ёслол болсноор худ ургийн харилцааны ёст бэлэг нь аажим аажмаар цагаан сарын бэлэг болж ойлгогдох болсон байна. Гэхдээ зарим хязгаар нутагт “хувь тос” гэж олгойны буланд

хөлдөөсөн цагаан тос, дугуй ааруул зэргийг хүүхдэд өгдөг ёс хэвээр байсан байна. Харин төв суурингийн хамаатнуудаас гадаад дотоодын чихэр, дэвтэр харандаа зэрэг хичээлийн хэрэгсэл, толгойн алчуур, ороолт, амны алчуур, хол ойрын сонин содон зүйлсээр бэлэг өгдөг болжээ.

Харин социализмын сүүлийн жилүүд болоод даяаршлын эхний жилүүдэд албан газрын золголт, айлчлал хавтгайрч, цагаан сарын бэлэг нь ураг төрлийн харилцааны утгаа алдаж эхэлсэн ба үүнийг дагаад “хүний гар тэнийлгэх” гэсэн хам олны харилцааны утга давамгайлах болжээ.

Монголын өнөөгийн нийгэмд өрнөж буй соёлын өөрчлөлт монгол бэлгийн соёлд хэрхэн нөлөөлж байгааг судлахдаа MNG судалгааны компанийн 2016 онд хийсэн асуулга судалгааны дүн хийгээд сүүлийн жилүүдэд хийсэн зарим гадаадын судлаачдын ажиглалт судалгааны баримттай харьцуулан авч үзье. 2014 онд ЖосефФрэсли Булган аймагт цагаан сараар хүмүүсийн өгч байгаа бэлэг дээр ажиглалт хийгээд “жигжиг эрдэнэт хивс, хайрцагтай шоколадаас эхлээд оймс бээлий, хөзөр зэрэг жигжиг бэлгүүд ч өгөгдөж байжээ. 1000-10000 төгрөгийг бас шууд өгөх нь байна.” гэсэн бол 2015 онд ЛизФокс Улаанбаатар хотын гэр хорооллын нэгэн гэр бүл ба Төв аймгийн нэгэн гэр бүлийн солилцож байгаа бэлгийн төрөл зүйл дээр ажиглалт хийхэд ноосон оймс, ороолт, подволк, чихэр, шоколад, 1000-5000 төгрөг, мобиком, скайтелийн цагаан сарын зурагтай нэгжийн карт зэргийг солилцож байна” гэхчлэн танилцуулаад *ямар нэгэн юмны валю гэдэг ойлголтыг мартаад бенефит гэдэг төрөл рүү орж ирээд утгаа лдажбана. Энэ нь ядуу буурай орон дээр илэрч байна. Наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагаас шалтгаалаад соёлын утга бэлгэдэлт утга, түүнээс авч байгаа таашаал гэдэг ойлголт байхгүй болж байна* (<http://blogs.ucl.ac.uk/Mongolian-economy/2016/03/08/tsagaan-sar-gift-index-2016/>) гэж тэмдэглэсэн байна.

Цагаан сарын бэлгийн талаар сүүлийн жилүүдэд хийсэн судалгаа болоод олон нийтийн хэвлэлийн бичвэрээс үзэхэд гол төлөв орчин үеийн суурьшмал ахуй амьдрал, зан үйлийн хэрэгцээ шаардлагыг тооцсон хямд бэлгийг олноор бөөндөн авч, хоорондоо хавтгайруулан дамжуулах байдал зонхилж, хүүхдэд гар утас, жийп машин зэрэг орчин үеийн шинэ соёлын эд зүйлсийн хэлбэрийг дуурайсан чанаргүй тоглоомыг авч өгөх болсон байна. Монгол бэлэгний соёл нь ийнхүү монгол хүний бэлгэдэх сэтгэлгээг саяхан болтол тогтвортой тусган хадгалж, ургийн доторх хүндэтгэлт харилцааг хүүхдэд бага наснаас нь таниулан сургадаг байсан хэдий ч даяаршлын нөлөө бүхий сүүлийн жилүүдэд энэ байдал маш хурдан алдагдах болжээ. “... *Нийгэм солигдох үеийн бэлэгнүүд өмнөх жилүүдийн бэлэгнээс өнгө зүсээрээ ялгарч эхлэв. Бэлэгний хувьслын хувьд агуулгаас илүү хэлбэр лүү шилжсэн үе ч гэж ойлгож болно. “Хүнд өгөхөд хөөрхөн харагдах юм байна”, “Гоё цаас, боодолтой юм” “Олноор нь авбал бүр хямдрах юм байна” гэх шалгуур цагаан сарын бэлгэнд орж ирэв. Тэр үеэс л цагаан сарын бэлэг жинхэнэ утгаа алдсан гэж болно...*” (Б.Энхмандах, Эх сурвалж: “NEWS WEEK” сонин №046)

Түүнчлэн уламжлалт нийгэмд цагаан сарын бэлэг нь ураг төрлийн харилцааг тодотгож байсан бол өнөө үед хүмүүсийн нийгмийн бүхий л харилцааг ил тодорхой бүтээж байна. Цагаан сарын бэлэг нь өдгөө ураг төрлийн харилцааны “хувь хүртээх” утгаасаа “хүний алга тэнийлгэх” гэсэн хам олны харилцааны утгатай болж өөрчлөгдсөнөөс чанаргүй бэлгийг бөөнөөр авч, орсон гарсан хэн хүнгүй тэгшитгэн тараах байдалд шилжсэн байна.

Даяаршлын үеийн нээлттэй нийгмийн харилцаа, олон соёлын нөлөөгөөр монгол бэлэгний бэлгэдэлт ангилал үндсэндээ халагдаж, хэрэглээний ач холбогдлыг чухалчлах сэтгэлгээнд дагуулж байна. Аливаа соёлын харилцааны үнэ цэнт чанарыг мартаад, ашиг хонжоо тооцохсэтгэлгээ рүү ороод ирэхээр соёл өөрийн үндсэн утгаа алдахад хүрдэг байна. Тодруулж хэлбэл, энэ нь өмнө тэмдэглэсэнчлэн нийгэм өөрөө наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагаас шалтгаалаад цагаан сарын соёлын харилцааны утга учир, бэлэгний бэлгэдэлт утга, тэдгээрээс авч байгаа дурсамж, таашаал гэдэг үнэт зүйлс эрсдэлд ороход ойртож байгааг харуулж байна.

Монголын цагаан сарын бэлгийн утга бүрэн алдрахад хүрээд буй энэ үед зарим аж ахуйн нэгж, хувь хүмүүс үндэсний хэлбэртэй бэлэг дурсгалын зүйлсийг үйлдвэрлэж, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих уриалга санаачлага өрнүүлснээр үндэсний онцлогтой бэлгийг худалдан авч бэлэглэх нь улам бүр нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байна. Даяаршлын жилүүдэд монголын цагаан сарын соёлд гарсан өөрчлөлтийн талаар бид цаашид үргэлжлүүлэн судлах болно.

Энэ бүхнээс дүгнэхэд,

Монголчуудын бэлэгний талаарх уламжлалт ойлголтыг цагаан сарын соёлын харилцаа хандлагатай харьцуулан судлаад бид дараах дүгнэлтийг хийж байна.

1. Монгол бэлэгний дүрүүд нь бусдын соёлын нөлөөгөөр өөрчлөгдсөөр бэлгэдлийн ангиллын шалгуур нь цагаан цайвар өнгөтэй, тэгш зөв хэлбэртэй, ижил хос юм уу үржих олшрох тоотой байх язгуур утгын хамтаар “энтэй артай” бөс торго, “эвлүүлж шахсан” цай идээн, мөртэй захтай хувцас, өөдөө амсартай сав гэх мэт шинэ шинэ утгаар баяжин тэмдэг бэлгэдлээ баяжуулан хөгжсөөр ирсэн байна.

2. Социализмын жилүүдэд монголчуудын эрхлэх аж ахуйн хэвшил солигдож, суурин иргэншлийн цагийн хуваариар ажиллаж амьдрах болсноор эд идээний олбороосоо “хувь хүртээх” гэр угсааныхны дотоод ёс, худ ургийн харилцааны “бэлэг” өгөх ёс зэрэг нь аажимдаа цагаан сарын баяртаа шилжин төвлөрсөн байна.

3. Харин аж хэрэглээний нийгэмд шилжиж, олон соёлын нөлөөг хүртэх болсон хожмын жилүүдэд бэлгийн бэлгэдэл утгын тухайд хэрэглээний сонирхол, ашгийн сэтгэлгээг халж чадсан соёлын дэвшлийн өмнөх ололтоо алдаж, улмаар “гар цайлгах ёс” – “бэлэг солилцох ёс” болгон хавтгайруулснаас цагаан сарын бэлэгний бэлгэдэлт утга, тэдгээрээс авч байгаа дурсамж, таашаал гэдэг үнэт зүйлс эрсдэлд ороход ойрхон байгааг харуулж байна.

НОМ ЗҮЙ

1. Арьяасүрэн Ч, Нямбуу Х. (1991). *Монгол ёс заншлын дунд тайлбар толь*. Редактор Г.Чингэл, “Сүүлэнхүү” хүүхдийн хэвлэлийн газар, УБ.,

2. Бум-Очир Д, Мөнх-эрдэнэ Г. (2012). *Нийгэм соёлын хүн судлалын онолын үүд*. Редактор С.Дулам, Г.Баттогтох, МУИС, Нийгэм соёлын антропологийн тэнхим. УБ.,

3. Дулам С. (1992). *Цагаан сарын бэлгэдэл*. Ариутган шүүсэн Х.Нямбуу. Улаанбаатар

4. Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн (2011). МУШУА-ийн Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургууль. Монгол ба дотоод Ази судлалын төв. I-X боть, Эрхэлсэн С.Чулуун. хянан нягталж оршил бичсэн Г.Цэрэнханд, У.Булаг. Улаанбаатар
5. Mauss, Marsel. 1924 (2000). *The Gift*. WW Norton & Co Inc.
6. Энхмандах Б. *Бэлэгний хувьсал*. Эх сурвалж: "NEWS WEEK" сонин №046 <http://www.news.mn/content/169167.sht>
7. *Бэлэг өгөх, гар цайлгах тухай*. Эх сурвалж: "Хөдөлмөр" Нийтэлсэн: 2015-02-18 11:20:09 <http://www.sonin.mn/news/culture/39850>
8. <http://blogs.ucl.ac.uk/Mongolian-economy/2016/03/01/the-cost-of-tsagaan-sar/>
9. <http://blogs.ucl.ac.uk/Mongolian-economy/2016/03/08/tsagaan-sar-gift-index-2016/>
10. Монголчуудын уламжлалт цагаан сарын баярт хандах хандлагын судалгаа. ММСГ судалгааны компаниас 2016 онд хийсэн асуулга судалгааны материал
11. Цагаан сарын соёлын өөрчлөлт” МУИС-ийн төслийн хүрээнд хийсэн түүвэр судалгааны материал

SUMMARY

This paper discusses the trend of comparative research on the relationship between a traditional concept of gift culture by the Mongolians and cultural changes of Mongolian *Tsagaan Sar* in the socialist era. The following conclusions have been drawn:

1. The figure of the gifts has been changed by other cultural influence though the symbolic meaning of them has been enriched meaningfully by their multiplied numbers, right shapes, and bright white colors and so on.
2. During the socialist period, the Mongolians' nomadic lifestyle has been transformed into the settled one. So that, gradually `share` or `gift` was commonly given during the celebration of *Tsagaan Sar*.
3. In cultural development, consumer-oriented thinking or benefit-based mind has been eliminated by the influence of different cultures. But today, `gift giving custom` or `gift exchanging custom` became common that shows the nature of gift has been losing its cultural value due to consumerism throughout diversified cultural effects.